



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД
ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН ТАНХИМД

МОНГОЛЫН ӨМГӨӨЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ

ГИШҮҮН ӨМГӨӨЛӨГЧ

Баатарсүрэнгийн БОЛДБААТАР

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,

Нэгдсэн үндэсний гудамж

6-р хороо, 45-6 тоот

Утас: 88118116

E-mail: lordboldbaatar@gmail.com,

boldbaatar@smartadvice.mn

Шуудангийн салбар: 46, Ш/х-1062

2024.08.27 № Г-07

танай _____-ны № _____-т

Хяналтын журмаар
гомдол гаргах нь:

Нийслэл дэх Захиргааны хэргийн Анхан шатны шүүхийн 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 128/ШШ2023/0766 дугаар шүүхийн Шийдвэр, Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхийн 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн МА2024/36 дугаар Магадлалыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1.шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах; 123.2.3.хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн; гэсэн үндэслэлээр эс зөвшөөрч хяналтын журмаар гомдол гаргаж байна. Үүнд:

1. Шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах.

Маргаан бүхий захиргааны актын тэмдэглэх хэсгийн 1, 2 дугаар заалтаас харахад хариуцагч нар нь нэхэмжлэгчийг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай 2006 оны хуулийн 8.2 “эрх бүхий байгууллагаас олгосон тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх, эсхүл эд хөрөнгө эзэмших, ашиглах эрхийг хуульд заасан хэлбэрээр бусдад шилжүүлснээс олсон орлого;” гэж заасны дагуу “эрх борлуулж” орлого олсон боловч тайлагнаагүй гэж буруутгасан. Ийнхүү буруутгахдаа маргаан бүхий захиргааны актад “суутгагч” хэмээх ойлголтын холбогдох хуулийн зохицуулалтыг огт ишлээгүй. /Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай 2006 оны хуулийн 4.1.6.“суутгагч”, 21.5.Энэ хуулийн 17.2.1-17.2.3, 17.2.7-17.2.9-д заасан орлогод ногдох албан татварыг мөн хуулийн 4.1.6-д заасан суутгагч ногдуулан суутган авч, ажлын 7 хоногийн дотор төсөвт шилжүүлнэ./

Гэтэл хариуцагч нар анхан шатны шүүх хуралдаан дээр нэхэмжлэгчийг “эрх борлуулж орлого олсон этгээд” бус харин эрх борлуулж орлого олсон этгээд болох Сэнгийн Отгонмөнхөд орлого оруулахдаа Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай 2006 оны хуулийн дагуу “суутгагч”-ийн үүргийг биелүүлж, татварыг суутган төсөвт төлөөгүй гэж буруутгаж, тайлбар хэлж мэтгэлцсэн болно.

Улмаар Анхан шатны шүүх, шийдвэрийн ҮНДЭСЛЭХ хэсгийн 6, 7, 8-д нэхэмжлэгчийг суутгагчийн үүрэг биелүүлээгүй гэж буруутгаж дор дурьдсан хуулийн заалтыг үндэслэл болгон хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн. Үүнд:

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай 2006 оны хуулийн

1 дүгээр зүйлийн 1.1.Энэ хуулийн зорилт нь **аж ахуйн нэгжийн орлого**д албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Мөн 4 дүгээр зүйлийн

4.1.5."аж ахуйн нэгж" гэж улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани, нөхөрлөл, хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, тэдгээртэй адилтгах орлогын албан татвар төлөх үүрэг бүхий **ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ**;

4.1.6."суутгагч" гэж **АЛБАН ТАТВАР ТӨЛӨГЧИД** олгосон орлогод энэ хуулийн дагуу албан татвар ногдуулан суутгаж, улсын болон орон нутгийн төсөвт шилжүүлэх үүрэг бүхий **ЭТГЭЭДИЙГ**;

5 дугаар зүйлийн /Албан татвар төлөгч/

5.1.Тухайн татварын жилд албан татвар ногдох **орлого олсон**, эсхүл тийм орлогогүй ч хуульд заасны дагуу албан татвар төлөх үүрэг бүхий **АЖ АХУЙН НЭГЖ** нь албан татвар төлөгч байна.

8 дугаар зүйлийн

8.1.Албан татвар төлөгчийн үйл ажиллагааны дараах орлогод албан татвар ногдоно:

8.2.**Эрх борлуулсны орлогод дараахь орлогыг хамааруулна:**

8.2.1."эрх бүхий байгууллагаас олгосон тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх, эсхүл эд хөрөнгө эзэмших, ашиглах эрхийг хуульд заасан хэлбэрээр бусдад шилжүүлснээс олсон орлого;"

Өөрөөр хэлбэл Шүүх "ЭН ТИ ЭН ЭЙЧ ДИ МЕДИА ГРУПП" ХХК-ийг суутган төлөгч гэж үзэж байгаа бол "ЭН ТИ ЭН ЭЙЧ ДИ МЕДИА ГРУПП" ХХК-иас орлого олсон этгээдийг **аж ахуйн нэгж гэж тогтоосон тохиолдолд** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай 2006 оны хуулийн 4.1.6."суутгагч" гэж үзэж хуулийг хэрэглэх нь үндэслэлтэй юм.

Гэтэл Анхан шатны шүүх "эрх шилжүүлсэн хувьцаа худалдсан гэрээний төлбөр нь "ЭН ТИ ЭН ЭЙЧ ДИ МЕДИА ГРУПП" ХХК-ийн дансад хийгдэж, уг данснаас С. Отгонмөнхийн данс руу шилжсэн нь Худалдаа хөгжлийн банкны дансны хуулгаар нотлогддог бөгөөд хэргийн оролшогч нар энэ үйл баримттай маргаагүй" гэж дүгнэж нэхэмжлэгч "ЭН ТИ ЭН ЭЙЧ ДИ МЕДИА ГРУПП" ХХК-ийг эрх борлуулагч биш, харин эрхээ борлуулсан С. Отгонмөнхөд орлого оруулж, зардал гаргасан этгээд гэж үзсэн аталаа ямар үндэслэлээр Нэмэгдсэн ертгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.-т "Үйл ажиллагааны **борлуулалтын** орлогын хэмжээ нь 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрч, албан татвар ногдуулан суутган авч, төсөвт төвлөрүүлэх үүрэг бүхий дараах этгээд албан татвар суутган төлөгч байна:"

- 5.2.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа, ажил, үйлчилгээний **борлуулалт хийсэн**;
- 5.2.2.бараа, ажил, үйлчилгээг импортоор оруулсан;
- 5.2.3.бараа, ажил, үйлчилгээг экспортод гаргасан.

7 дугаар зүйлийн 7.2.Доор дурдсан үйл ажиллагааг 7.1-д нэгэн адил хамааруулна: 7.2.1.эрх борлуулах; мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.Энэ хуулийн 7.1, 7.2-т заасан бараа, ажил, үйлчилгээнд албан татвар ногдуулахад доор дурдсан нөхцөлийг хангасан байна:

7.3.1.тухайн этгээд нь энэ хуулийн 5, 6 дугаар зүйлд заасны дагуу албан татвар суутган төлөгч байх;

7.3.2.борлуулалтыг аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд хийсэн байх. гэж заасныг тус тус үгүйсгэн, Нэмэгдсэн өртөгийн албан татварын тухай хуулийн дагуу эрх борлуулсан гэсэн зохицуулалтад хамаарах С. Отгонмөнхийн нэмэгдсэн өртөгийн албан татвар суутгаж төсөвт төлөх үүргийг “ЭН ТИ ЭН ЭЙЧ ДИ МЕДИА ГРУПП” ХХК хариуцах ёстой гэж шийдвэрлээд байгаа нь ойлгомжгүй байна.

Анхан шатны шүүх Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай 2006 оны хуулиар “ЭН ТИ ЭН ЭЙЧ ДИ МЕДИА ГРУПП” ХХК-ийг "суутгагч" гэж үзсэн бол орлого олж буй этгээд нь бараа, ажил, үйлчилгээний борлуулалтаасаа нэмэгдсэн өртөгийн албан татвар суутгаж төсөвт төлөх үүрэгтэй гэснийг анхаарсангүй.

“Дүрмийн дагуу” Захиргааны хэргийг Давж заалдах журмаар хэлэлцсэн шүүх хуралдаан дээр хариуцагч нар тайлбараа Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай 2006 оны хуулийн “8.2.2.хуулийн этгээд, түүний эцсийн эзэмшигч хувьцаа, хувь оролцоогоо бусдад шилжүүлэх замаар ...” нэхэмжлэгчийг орлого олсон гэж өөрчилсөн.

Улмаар Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүх Магадлалын ХЯНАВАЛ хэсгийн “2.6 ... анхан шатны шүүхийн шийдвэр үндэслэлтэй.”, “ 2.8... тухай компаниудад хувьцаа худалдах замаар эрх борлуулсан гэж үзэхээр байна.”, “2.11 Иймээс Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль /2006 он/-ийн 8.2.1.эрх бүхий байгууллагаас олгосон тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх, эсхүл эд хөрөнгө эзэмших, ашиглах эрхийг хуульд заасан хэлбэрээр бусдад шилжүүлэх замаар эрх борлуулсан байгаа энэ тохиолдолд мөн хуулийн 8.2.2-т “хуулийн этгээд, түүний эцсийн эзэмшигч хувьцаа, хувь оролцоогоо бусдад шилжүүлэх замаар газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн эцсийн эзэмшигчийг өөрчлөх замаар олсон орлогод татвар ногдуулна” заасантай адилтган үзэж эрх эзэмшигч нэхэмжлэгч компанид татвар ногдуулсныг буруутгах боломжгүй.” гэсэн дүгнэлтийг хийсэн.

Анхан шатны шүүх нэхэмжлэгчийг эрх борлуулсан этгээд бус харин эрх борлуулсан этгээдэд орлого оруулсан этгээд гээд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай 2006 оны хуулийн 4.1.6."суутгагч" мөн хэмээн үзсэн бол Давж заалдах шатны шүүх, анхан шатны шүүхийн шийдвэр үндэслэлтэй гэсэн боловч шийдвэрээс нь тэс өөрөөр буюу нэхэмжлэгчийг “эрх борлуулсан этгээд” буюу хувьцаагаа бусдад худалдах журмаар эрх борлуулсан этгээд гэж анхан шатны шүүхийн шийдвэрийг үгүйсгэсэн дүгнэлт хийв.

Хэдийгээр анхан болон давж заалдах шатны шүүх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон нэг шийдэлтэй боловч Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай /2006 он/ ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭНИЙ ЗӨРҮҮ нь тэнгэр газар шиг ялгаатай болов.

Анхан болон давж заалдах шатны шүүх нэхэмжлэгчийг ямар үндэслэлээр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1."борлуулалт" гэж барааг бусдын өмчлөлд шилжүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхийг; 4.1.2. "бараа" гэж мөнгөн хөрөнгөнөөс бусад бүх төрлийн хөрөнгийг; гэж заасан зохицуулалтад хамаарч эрхээ бусдын өмчлөлд шилжүүлсэн талаарх дүгнэлт өгсөнгүй.

Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүх Магадлалын ХЯНАВАЛ хэсгийн 2.11 “Иймээс Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль /2006 он/-ийн 8.2.1.эрх бүхий

0244

байгууллагаас олгосон тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх, эсхүл эд хөрөнгө эзэмших, ашиглах эрхийг хуульд заасан хэлбэрээр бусдад шилжүүлэх замаар эрх борлуулсан байгаа энэ тохиолдолд мөн хуулийн 8.2.2-т “хуулийн этгээд, түүний эцсийн эзэмшигч хувьцаа, хувь оролцоогоо бусдад шилжүүлэх замаар газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн эцсийн эзэмшигчийг өөрчлөх замаар олсон орлогод татвар ногдуулна” гэж заасантай адилтган үзэж эрх эзэмшигч нэхэмжлэгч компанид татвар ногдуулсныг буруутгах боломжгүй.” гэсэн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй юм.

Хуулийг адилтган хэрэглэх зарчим байхгүй харин төсөөтэй хэрэглэнэ гэсэн зарчим байдаг.

Иргэний хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.Иргэний хуульд тухайн харилцааг зохицуулсан хэм хэмжээ байхгүй бол түүнтэй төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээг хэрэглэнэ. 4.2.Төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээ байхгүй бол тухайн харилцааг иргэний эрх зүйн агуулга, зарчим, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд нийцүүлэн зохицуулна. 4.3.Тусгай харилцааг тухайлан зохицуулсан хэм хэмжээг бусад харилцаанд төсөөтэй хэрэглэж үл болно. гэсэн зарчим хэдийгээр Иргэний хуульд орсон боловч энэхүү зарчим нь эрх зүйн онол, сургаалийн гол зарчим тул нийтийн эрх зүйд бас хэрэглэгдэнэ.

Иргэний хуульд заасан эрх зүйн онолын гол зарчмууд нийтийн эрх зүйд хэрэглэгдсэн цөөнгүй тохиолдол байдаг.

Тухайлбал Эрүүгийн хуульд нэмэлт, оруулах тухай 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 267, 272 дугаар зүйл хүчингүй болгосныг Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.“Хуулийг хүчингүй болгох тухай хуулийг хүчингүй болгосноор өмнө хүчингүй болгосон хуулийн үйлчлэл сэргэхгүй.” гэсэн зарчмын дагуу Эрүүгийн хуульд нэмэлт оруулах 2008 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн тусгай ангид хүчингүй болсон 267, 272 дугаар зүйлийг нэмсэн.

Тиймээс Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль /2006 он/-8.2.2-т “хуулийн этгээд, түүний эцсийн эзэмшигч хувьцаа, хувь оролцоогоо бусдад шилжүүлэх замаар газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн эцсийн эзэмшигчийг өөрчлөх замаар олсон орлогод татвар ногдуулна” гэж газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой тусгай харилцааг зохицуулсан хэм хэмжээг төсөөтэй байдлаар бусад хэм хэмжээнд адилтган хэрэглэхгүй.

2. Хүүлийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн.

Татварын эрх зүйн харилцаа ямар субъектуудын хооронд үүсч, харилцаанд юу өртөөд байгаа юм, энэхүү субъектүүд юуг өгч, аваад, хэн /юу/ хэрхэн орлого олсон юм. Өөрөөр хэлбэл: Хэн орлого олоод, хэнээс зардал гараад байгаа юм, орлого, зардал гарсантай холбоотой татварын хууль тогтоомжоор талуудын эдлэх эрх, үүргийг зайлшгүй зөв, эргэлзээгүй тодорхойлох ёстой.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.“борлуулалт” гэж барааг бусдын өмчлөлд шилжүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхийг; 4.1.2. “бараа” гэж мөнгөн хөрөнгөнөөс бусад бүх төрлийн хөрөнгийг; гэж заажээ. “ЭН ТИ ЭН ЭЙЧ ДИ МЕДИА ГРУПП” ХХК нь ямар гэрээгээр ямар барааг борлуулж, хэний өмчлөлд шилжүүлсэн тухай захиргааны хэрэгт баримт огт авагдаагүй. Татварын улсын байцаагчдын гол барьж буй нотлох баримт болох Сэнгийн Отгонмөнх, “Хүрэл интернэшнл” ХХК, “Смарт Коммуникэйшн” ХХК-ийн хоорондын байгуулагдсан “Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ”, “Эрх шилжүүлэх

гэрээ"-нд "ЭН ТИ ЭН ЭЙЧ ДИ МЕДИА ГРУПП" ХХК нь ямар барааг хэнд шилжүүлэх тухай огт байхгүй харин талуудын харилцаанд өртөгдөж буй зүйл болсон байдаг.

Нэхэмжлэгчийн "Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл" нь борлуулагдаад бусдад шилжсэн зүйл огт байхгүй, "ЭН ТИ ЭН ЭЙЧ ДИ МЕДИА ГРУПП" ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй хэвээр байгаа болно.

Тодруулбал: Хариуцагч нар нь "Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ", "Эрх шилжүүлэх гэрээ" -г татан авч анхан шатны баримтаар үнэлсэн боловч гэрээний тал болон суутган төсөвт төлөх үүрэг бүхий этгээдийг зөв тодорхойлж чадаагүй, эрх зүйн онол, /эрүүгийн эрх зүй/ сургаальд байдаг гэм буруугийн андуурал хэмээх ойлголтод хамаардаг "ОБЪЕКТЫН АНДУУРАЛ" гаргаж, татвар суутган төлөх үүрэггүй этгээдээр суутган төлүүлэхийг шаардсан байна.

Хариуцагч болон шүүхүүдийн Татварын эрх зүйн харилцааны бүтэц болох субъект, объект, агуулгыг зөв тодорхойлж чадахгүй байгаад тодорхой хариулт болсон тогтоолыг Монгол Улсын Дээд Шүүх гаргасан байдаг.

Монгол Улсын Дээд Шүүхийн 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 0061 дугаар тогтоолд оруулсан "...Татварын ерөнхий хууль болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд зааснаар "орлого олсон тохиолдолд татвар төлөх үүрэг үүсэх" бөгөөд бусдад орлого шилжүүлж буй этгээд нь орлого олж буй этгээдийн төлвөл зохих татварыг суутган авч төсөвт төлөх үүрэгтэй байна. Энэ тохиолдолд, "ИГЦ" ХХК нь өөрөө ямар нэг орлого олоогүй, бусдад ямар нэг орлого шилжүүлээгүй, Хувьцаа худалдах-худалдан авах гэрээний оролцогч биш байх тул татвар суутган төлөх үүрэг үүсээгүй буюу татвар суутган төлөгч биш байна.

Өөрөөр хэлбэл, Хувьцаа худалдах-худалдан авах гэрээгээр "ИГЦ" ХХК-ийн 100 хувийн хувьцааг зарж орлого олсон тал нь иргэн С, Ч нар, худалдан авсан тал буюу тэдэнд орлого шилжүүлсэн этгээд нь иргэн Б болох нь тодорхой байхад "ИГЦ" ХХК-ийг татвар суутган төлөх үүрэгтэй гэж үзэхгүй, шүүхүүд энэ талаар буруу дүгнэлт хийсэн гэж дүгнэж, шүүхийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулав..." гэсэн байна.

Бидний маргаад байгаа гол зүйл ердөө л энэ гэрээний тал биш, орлого олсон этгээд биш байхад татварын суутган төлөгчийн үүрэг үүсэхгүй хэмээн маргасан.

Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүх магадлалын ХЯНАВАЛ хэсгийн "2.13. ...тус хуулийн өөрчлөлтөөс өмнөх үйл баримтыг дүгнэсэн шүүхийн шийдвэрийг энэ хэрэгтэй адилтган тайлбарлаж байгааг шүүх хүлээн авах боломжгүй" гэснийг эс зөвшөөрч байна.

Анхан болон Давж заалдах шатны шүүх хариуцагч нар маргаан бүхий захиргааны актыг үйлдэхдээ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль /2006 он/-д 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт орохоос өмнөх байдлаар буюу "8.2" гэсэн дугаарлагдсан байдал болон мөн хуулийн 21 дүгээр зүйл заасан үүрэг хэний үүрэг болох тал дээр дүгнэлт хийгээгүй.

Монгол Улсын Дээд Шүүхийн 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 0061 дугаар тогтоол нь манай тохиолдлоос өмнөх харилцаанд хамаарах хэдий ч татварын эрх зүйн харилцааг зөв тодорхойлох /субъект, объект болон агуулгыг/ талаар түлхүүр, жишиг болсон шийдвэр байна гэж ойлгож байна.

Эцэст нь: "Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ", "Эрх шилжүүлэх гэрээ" -ний тал болсон "Хүрэл интернэшл" ХХК, "Смарт Коммуникэйшн" ХХК нь гэрээний төлбөр болох

595,095,000.00 төгрөгийг С. Отгонмөнхөд шилжүүлэхдээ “ЭН ТИ ЭН ЭЙЧ ДИ МЕДИА ГРУПП” ХХК-нд 484,000,000.00 шилжүүлсэн байдаг.

“Хүрэл интернэшнл” ХХК, “Смарт Коммуникэйшн” ХХК нь хувь хүн С. Отгонмөнхөд олгосон орлого шилжүүлэхдээ суутганы үүргээ биелүүлж, татвар суутгасан дүнгээр буюу 484,000,000.00 төгрөгийг шилжүүлснийг шүүх анхаарч үзэлгүй, татварыг давхардуулан ногдуулах гэж байна.

Иймд Нийслэл дэх Захиргааны хэргийн Анхан шатны шүүхийн 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 128/ШШ2023/0766 дугаар шүүхийн Шийдвэр, Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхийн 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн МА2024/36 дугаар Магадлалыг тус тус хүчингүй болгож, нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж өгнө үү.

Хавсралт 1 хуудас.

ХЯНАЛТЫН ЖУРМААР ГӨМДӨЛ ГАРГАСАН

ӨМГӨӨЛӨГЧ



Б.БОЛДБААТАР

